



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 8 дугаар сарын 4

Дугаар 5

Улаанбаатар хот

V ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын хуралдаан 2024 оны 8 дугаар сарын 4-ний өдрийн 11.00 цагт Төрийн ордон дахь “Сүхбаатар танхим”-д 89.5 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, хугацаатай үүрэг даалгавар өгөв.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ:

1. Улаанбурхан халдварт өвчний нөхцөл, авч хэрэгжүүлж байгаа хариу арга хэмжээний талаар

Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайхан

2. Бусад

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайханд:

1.1. Гамшгаас хамгаалах Эрүүл мэндийн улсын албаны үйл ажиллагааг идэвхижүүлж, хариу арга хэмжээг удирдлага зохицуулалтаар хангах, тандалт, дархлаажуулалт, бэлэн байдлыг хангахад шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэх;

1.2. Улаанбурхан өвчний дэгдэлтийн үед хариу арга хэмжээнд татан оролцуулах хүч хэрэгсэл, нөөцийг бүрдүүлэх, авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлтийг нарийвчлан гаргах;

1.3. Тандалтыг эрчимжүүлж, дэгдэлтийн үеийн дархлаажуулалтыг шуурхай зохион байгуулах, товлот болон нөхөн дархлаажуулалтыг эрчимжүүлэх;

Хоёр. Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайхан, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ц.Баатархүү, Зам тээврийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Дэлгэрсайхан, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн, хошууч генерал Х.Лхагвасүрэн, Гаалийн ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн Р.Отгонжаргал нарт:

2.1. Улаанбурхан өвчний зөөвөрлөгдсөн тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан хилийн нэвтрэх цэгт гадаад улсаас ирж буй зорчигчдод тавих эрүүл мэндийн хяналтыг идэвхижүүлэх, нэвтэрч буй зорчигчийн очих газрын хаяг, утасны дугаар гэх мэт эргэн холбоо тогтооход шаардлагатай мэдээлэл цуглуулах нөхцөлийг хангаж, эрүүл мэндийн байгууллагатай мэдээлэл солилцож ажиллах;

2.2. Хилийн нэвтрэх цэгт тавих эрүүл мэндийн хяналтыг зорчигчдод хүндрэл, чирэгдэлгүй байхаар төлөвлөн зохион байгуулж, Улсын онцгой комисст танилцуулан зөвшөөрөл авч хэрэгжүүлэх;

Гурав. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ц.Баатархүү, Тагнуулын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн, хошууч генерал П.Одонбаатар, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Т.Сүхболд нарт:

3.1. Улаанбурхан өвчний голомтын цар хүрээг тодорхойлох тархвар зүйн тандалт, судалгаа хийх, тархалтаас урьдчилан сэргийлэх зэрэг эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд мэдээллийн дэмжлэг үзүүлж, шаардлагатай ажилтан, алба хаагчдыг томилгоожуулан ажиллуулах;

Дөрөв. Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайхан, Боловсролын сайд П.Наранбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Улсын онцгой комиссын гишүүн Х.Батжаргал, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт:

4.1. Хичээлийн шинэ жил эхлэх үед ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг зэрэг боловсролын байгууллагуудад улаанбурхан өвчний дэгдэлт үүсэх эрсдэлийн үнэлгээг нарийвчлан хийж, халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эртнээс авч хэрэгжүүлэх;

Тав. Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайхан, ЗГХЭГ-ын Хэвлэл мэдээлэл, Олон нийттэй харилцах газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн Т.Ганзул, Монголын Улаан Загалмай Нийгэмлэгийн Ерөнхий нарийн бичгийн дарга, Улсын онцгой комиссын гишүүн Н.Болормаа нарт:

5.1. Улаанбурхан өвчний халдвар, түүнээс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтад хамрагдах талаар холбогдох зөвлөмж, сэрэмжлүүлэг мэдээ, мэдээллийг түгээх, олон нийтэд буруу ташаа мэдээлэл тарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах;

Зургаа. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт:

6.1. Улаанбурхан өвчний тандалт, дархлаажуулалт, хариу арга хэмжээ зохион байгуулах болон бэлэн байдлыг хангахад шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэн, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад дэмжлэг үзүүлж ажиллах;

6.2. Орон нутгийн хэмжээнд эрсдэлийн үнэлэгээ хийж, халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг Эрүүл мэндийн яам болон бусад мэргэжлийн байгууллагын удирдамж, зөвлөмжийн дагуу бүх шатанд авч хэрэгжүүлэх;

Шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, танилцуулж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга, хурандаа Т.Баярхүү нарт даалгах.

ДАРГА

С.АМАРСАЙХАН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ХУРАНДАА

Т.БАЯРХҮҮ